

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/01/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 262071 Цахим хаяг: Bolor-erdened@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунжаргал
Утас: 262071 Цахим хаяг: Ariunjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.4.1 Завсрын аудитын талаар.....	16
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Нийгмийн халамжийн дэд сангууд	17
5.2 Нийгмийн халамжийн төв сан.....	17
5.2.1 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЯ	Сангийн яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/821

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт; мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 325.0 мянган төгрөгөөр буюу 1.1 дахин, 2020 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 275.0 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг нийгмийн халамжийн үйлчилгээ болгон Нийгмийн халамжийн сангаас олгохоор шийдвэрлэж 1,305,322 хүүхдэд 1,520,097.2 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон нь нийгмийн халамжийн сангаас олгосон нийт тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний зардлын 69.0 хувийг эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 12 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,930.2	33,293.2
33	АВЛАГА	26,930.2	33,293.2
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,603.2	7,603.2
33300	Татаас, санхүүжилтийн авлага	19,327.0	12,990.0
33500	Бусад авлага	-	12,700.0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	12,700.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,930.2	33,293.2
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,100.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	1,100.0
41360	Бусад өглөг	-	1,100.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,100.0
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,930.2	32,193.2
51	Засгийн газрын хувь оролцоо	26,930.2	32,193.2
51200	Хуримтлагдсан үр дүн	26,930.2	32,193.2
51210	Өмнөх үеийн үр дүн	1,102,204.7	26,930.2
51220	Тайлант үеийн үр дүн	(1,075,274.5)	5,263.0
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,930.2	33,293.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	546,821,779.6	2,217,389,291.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,336,163.1	877,145.5
120	Нийтлэг татварын бус орлого	15,336,163.1	877,145.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,336,163.1	877,145.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,336,163.1	877,145.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	531,485,616.5	2,216,512,145.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	528,284,801.5	2,209,031,220.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	528,284,801.5	2,209,031,220.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,815.0	7,480,925.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	104,240.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,096,575.0	7,480,925.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	547,897,054.1	2,217,384,028.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	547,897,054.1	2,217,384,028.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,125,923.8	1,073,865.6
2107	Томилолт, зочны зардал	49,816.8	-
210702	Дотоод албан томилолт	49,816.8	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,045,598.6	1,060,594.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	917,198.1	1,060,534.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,112.2	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	119,288.3	60.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,508.5	13,271.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,508.5	13,271.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	546,771,130.3	2,216,310,162.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	514,982,843.0	2,125,314,229.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	514,982,843.0	2,125,314,229.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,788,287.3	90,995,933.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,224,388.7	90,082,760.9
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,591.5	36,616.9
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	14,560,307.1	876,555.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,075,274.5)	5,263.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,075,274.5)	5,263.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	546,821,779.6	2,217,408,618.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,336,163.1	877,145.5
120	Нийтлэг татварын бус орлого	15,336,163.1	877,145.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,336,163.1	877,145.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,336,163.1	877,145.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	531,485,616.5	2,216,531,472.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	528,284,801.5	2,209,031,220.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	528,284,801.5	2,209,031,220.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,815.0	7,500,252.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,096,575.0	7,500,252.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	548,102,314.6	2,217,408,618.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	548,102,314.6	2,217,408,618.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,126,821.7	1,073,865.6
2107	Томилолт, зочны зардал	49,816.8	-
210702	Дотоод албан томилолт	49,816.8	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,046,496.4	1,060,594.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	918,096.0	1,060,534.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,112.2	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	119,288.3	60.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,508.5	13,271.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,508.5	13,271.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	546,975,492.9	2,216,334,752.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	515,167,878.6	2,125,325,829.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	515,167,878.6	2,125,325,829.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,807,614.3	91,008,923.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,224,582.7	90,083,350.9
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	22,724.5	49,016.9
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	14,560,307.1	876,555.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,280,535.0)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,280,535.0)	-
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,280,535.0	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>	
	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,039,653.1	1,039,653.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	62,551.6	62,551.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,102,204.7	1,102,204.7
Тайлант үеийн үр дүн	(1,075,274.5)	(1,075,274.5)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,930.2	26,930.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,930.2	26,930.2
Тайлант үеийн үр дүн	5,263.0	5,263.0
2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	32,193.2	32,193.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,209,031,220,500.00	2,118,948,459,600.60	90,082,760,899.40	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,209,031,220,500.00	2,118,948,459,600.60	90,082,760,899.40	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,326,470,700.00	1,073,865,568.15	252,605,131.85	81.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,311,661,400.00	1,060,593,968.15	251,067,431.85	80.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,173,909,000.00	1,060,533,968.15	113,375,031.85	90.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	137,752,400.00	60,000.00	137,692,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,809,300.00	13,271,600.00	1,537,700.00	89.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,809,300.00	13,271,600.00	1,537,700.00	89.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,207,704,749,800.00	2,117,874,594,032.45	89,830,155,767.55	95.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,207,704,749,800.00	2,117,874,594,032.45	89,830,155,767.55	95.9
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,207,704,749,800.00	2,117,874,594,032.45	89,830,155,767.55	95.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,209,031,220,500.00	2,118,948,459,600.60	90,082,760,899.40	95.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,209,031,220,500.00	2,118,948,459,600.60	90,082,760,899.40	95.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,209,031,220,500.00	2,118,948,459,600.60	90,082,760,899.40	95.9

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,500,252,038.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,500,252,038.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,500,252,038.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,451,235,138.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	7,451,235,138.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	49,016,900.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	49,016,900.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,500,252,038.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,500,252,038.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,500,252,038.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зорилго нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэхэд оршино. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;
- Төрд байгаа иргэний мэдээллийг иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ, арга хэмжээнд хамруулах, түргэн шуурхай хүргэх, халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/ цахим системийг нэвтрүүлж, үйлчилгээний менежментийг сайжруулах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн тэтгэмж
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам болон салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актаар зохицуулагдаж байгаа ба Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд дараах нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

- Халамжийн тэтгэвэр
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж
- Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж
- Цалинтай ээж
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
- Асрамжийн үйлчилгээ
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж хөнгөлөлт
- Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэл
- Насны хишиг

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийгмийн халамжийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Ахмад настны хууль;
- Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль;
- Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль;
- Сангийн сайдын 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар 2023 онд нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой дараах хяналт, шалгалтыг хийхээр төлөвлөж, гүйцэтгэсэн ба дотоод аудитаар нийт 487.1 сая төгрөгийг нийгмийн халамжийн санд төвлөрүүлсэн байна. Үүнд:

- *Төлөвлөгөөт хяналт, шалгалт:* Сүхбаатар, Баянзүрх дүүргийн ХХҮХ, Баян-Өлгий, Булган, Увс, Ховд, Дорноговь, Өмнөговь, Дорнод аймгийн ХХҮГ-ын Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт;
- *Төлөвлөгөөт бус болон эрсдэлд суурилсан хяналт, шалгалт:* Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний гүйцэтгэл.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авч, тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй учир дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын 2018 оны А/174 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж, дээрх баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

НХС-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.4 сая төгрөгөөр буюу 23.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	26,930.2	33,293.2	6,363.0
Нийт хөрөнгө	26,930.2	33,293.2	6,363.0
Өр төлбөр	-	1,100.0	1,100.0
Засгийн газрын хувь оролцоо	26,930.2	32,193.0	5,263.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	26,930.2	33,293.2	6,393.0

Авлага дансны үлдэгдэлд өмнөх оноос дамжин ирсэн Налайх дүүргийн ХХҮХ-ийн илүү олгосон 7.6 сая төгрөгийн иргэдээс авах авлага, Сангийн яаманд төвлөрүүлсэн 0.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүждэг олон нийтийн халамж үйлчилгээний нэр данс зөрүүтэй буцсан

гүйлгээний 12.4 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цахим системийн доголдлоос давхардуулан олгосон 12.7 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 1.1 сая төгрөгийн Сангийн яамны Төрийн сангийн банк хоорондын төлбөр тооцооны системд гарсан доголдлоос шалтгаалж үүссэн жилийн эцсийн санхүүгийн тайланд 11 хүүхдэд олгох тэтгэмжийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 32.3 сая төгрөг болж, 6.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 660,259.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас халамжийн зардлыг 75,279.0 сая төгрөгөөр бууруулж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 1,367,019.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1,952,000.2 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн сангаас олгохоор, мөн МУЗГ-ын 2023 оны 237 дугаар тогтоолоор 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэмжийг 325.0-650.0 мянган төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар НХС-аас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 7 дугаар сарын 01-ний өдрөөс бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан улсын төсвөөс 2,209,031.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 18 арга хэмжээг улсын төсвөөс 2,209,031.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 2,118,948.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,118,948.5 сая төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь халамжийн тэтгэврийг 40,021.0 сая төгрөг, хүүхэд асарсны тэтгэмжийг 19,175.5 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 14,122.2 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний тэтгэмжийг 7,269.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний нэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
1	Код	Нийт дүн	2,209,031,220.5	2,118,948,459.6	90,082,760.9	95.9
1.1	213203	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	473,554.7	473,554.7	-	100.0
1.2	213203	Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	32,019,541.7	29,284,238.5	2,735,303.2	91.5
1.3	213203	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	31,693,786.8	31,486,172.3	207,614.5	99.3
1.4	213203	Насны хишиг	27,645,109.8	26,662,317.2	982,792.6	96.4
1.5	213203	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1,534,219,423.4	1,520,097,236.5	14,122,186.9	99.1
1.6	213203	Хүүхэд асарсны тэтгэмж	97,067,679.7	77,892,203.9	19,175,475.8	80.2
1.7	213203	Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	16,329,088.7	16,327,438.7	1,650.0	100.0
1.8	210902	Хичээл үйлдвэрлэлийн зардал	14,809.3	13,271.6	1,537.7	89.6
1.9	210801	Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа ажил үйлчилгээ	266,191.0	238,750.5	27,440.5	89.7
1.10	210809	Улсын мэдээллийн маягт бэлтгэх	137,752.4	60.0	137,692.4	-
1.11	213203	Халамжийн тэтгэвэр	237,814,146.5	197,793,182.7	40,020,963.8	83.2
1.12	213203	Асаргааны тэтгэмж	126,458,848.9	125,245,681.6	1,213,167.3	99.0
1.13	213203	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	56,600,000.0	53,757,605.0	2,842,395.0	95.0
1.14	213203	Жирэмсэн эхийн тэтгэмж	11,108,116.5	10,139,645.1	968,471.4	91.3
1.15	213203	ХБИ-д үзүүлэх тусламж, хөнгөлөлт	11,951,819.8	11,661,419.1	290,400.7	97.6
1.16	213203	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	22,814,633.3	15,544,898.7	7,269,734.6	68.1
1.17	210801	АДЗ-ийн гишүүдийн урамшуулал	907,718.0	821,783.5	85,934.5	90.5
1.18	213203	Ихэр хүүхдийн тэтгэмж	1,509,000.0	1,509,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд харьяа байгууллагын орон нутгийн төсвийн санхүүжилтээс 7,500.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээний зардалд 7,451.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 49.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Засгийн газрын тусгай сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн сангийн хөрөнгийг зохистой удирдах, төсвийн хэмнэлт, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Б.Ариунжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/290 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 2,118,948.5 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 21,189.5 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд дахин хянаад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн халамжийн төв сан шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 14,978.2 сая төгрөгийн зарлагын 10 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Харьяа нийгмийн халамжийн дэд сангуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 82.5 сая төгрөгийн зөрчилд илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Нийгмийн халамжийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулж, аудитаар нийт 25.1 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгснөөс 7.6 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйг аудитын тайланд тусгалаа.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 7,495.1 сая төгрөгийн 5 зөрчлөөс 125.0 сая төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж, хэрэгжилт 10.4 хувьтай байна.

Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	7,487,500.3	2	125,000.0	20.7
Зөвлөмж	1	7,603.2	-	-	0
Нийт дүн	5	7,495,103.5	2	125,000.0	10.4

Өмнөх аудитаар хүргүүлсэн 7,348.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулсан 26 ахмад настны амралтын үйлчилгээ, 32 сувиллын үйлчилгээ үзүүлэх нийт 58 байгууллагатай гэрээ дүгнэсэн акт үйлдэж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсанд хариуцлага тооцуулах албан шаардлага, мөн 7.6 сая төгрөгийн авлага барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн 70.0 орчим хувийг нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд буюу хүүхдийн мөнгөн тэтгэмж, алдарт эхийн одонтой эхэд олгох тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмжид олгосон зарцуулалт нь нийгмийн халамжийн тухай хуульд тусгайлан заасан зорилтод бүлгийн халамжийн тэтгэмжийн санхүүжилтээс харьцангуй өндөр үзүүлэлттэй байгаа тул нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой тодорхойлж зорилтот бүлэгт чиглүүлэх, эх, хүүхдэд олгож байгаа тэтгэмж, урамшууллын бодлогыг Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжоос ялгаж зааглах талаар Нийгмийн халамжийн багц хуульд өөрчлөлт оруулж, санал хүргүүлэхээр төлөвлөсөн нь анхаарал хандуулах асуудал байна.

Мөн тус сангаас олгож байгаа байнгын асаргаа шаардлагатай иргэний асрагчид сар бүр олгодог байнгын асаргааны тэтгэмж, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон тэтгэмжийн санхүүжилтийн зарцуулалтад түүврийн горим сорил хэрэгжүүлсэн хэдий ч цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 312.8 сая төгрөгийн бүртгэл тайлагналын 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 9,416.6 сая төгрөгийн 11 зөрчил² илэрснээс, 1,842.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 365.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 51.3 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж, 7,157.6 сая төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт 9,416.6 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Нийгмийн халамжийн дэд сангууд

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 30 дэд сангийн санхүүгийн тайланг нэгтгэн аудитад хамруулсан.

Аудитаар 8 нийгмийн халамжийн дэд сангийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, 22 дэд сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Нийгмийн халамжийн дэд сангуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 293.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 293.5 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 51.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.2 Нийгмийн халамжийн төв сан

Нийгмийн халамжийн төв сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 19.3 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг өмнөх үеийн үр дүн данс руу хаасан алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа.

Аудитаар Нийгмийн халамжийн төв санд нийт 9,365.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,842.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 365.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 7,157.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.1 Албан шаардлага

1. Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэмжийг 2017-2023 оны хооронд нийт 35 хүүхдийн 365.3 сая төгрөгийг 9 асрамжийн төвийн 3 захирал, 2 багш, 4 нийгмийн ажилтны дансаар дамжуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нийгмийн халамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.4-т "16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.", Гэр бүлийн тухай хуулийн 25.3-т "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална.", 25.4-т "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгож буй тэтгэмжийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, зорилтод

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байгаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэв.

2. Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2019-2023 оны хооронд 1000 гаруй хүүхдэд 2,655.2 сая төгрөг, тайлант онд 800 гаруй хүүхдэд 943.5 сая төгрөг олгосон боловч халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, хүүхдийн мөнгөн тэтгэмж зорилтот бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй, мөнгөн хадгаламжид эрсдэл үүссэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд олгож буй хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй, хүүхдийн мөнгөн тэтгэмж зорилтот бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Нийгмийн халамж хариуцсан мэргэжилтнүүд 11 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн 876.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг бүртгэх явцад тэтгэмжийн дуусах хугацааг алдаатай оруулсан, үйлчилгээний шифр андуурсан, мөнгөн дүнг буруу бүртгэсэн зэрэг алдаатай бүртгэлийн үйл ажиллагааны улмаас тэтгэмжийг давхардуулан олгож, иргэдээс буцааж суутгасан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийгмийн халамжийн сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д "Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг алдаатай, давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

4. ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/105 дугаар тушаалаар ахмад настанд амралтын үйлчилгээ үзүүлэх 29, сувиллын үйлчилгээ үзүүлэх 42 газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, 7,157.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон гэрээний гүйцэтгэлийг дүгнэж акт үйлдээгүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-т "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т "Тухайн жилийн гэрээний хэрэгжилтийн тайланг энэхүү гэрээний хавсралтын дагуу гарган 2024 оны 01 дүгээр сарын 15-ны дотор агентлагт бичгээр хүргүүлэн гэрээг дүгнүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсний дагуу аудитын шийдвэрийг гаргав.

Шийдвэрлэсэн нь: Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй зөрчлийг давтан гаргасан, төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буруутай албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5. Санхүүгийн тайланд бүртгэлтэй хувь хүмүүсээс авах 7.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулаагүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

6. ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/305 дугаар тушаалаар нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөс 14.8 сая төгрөгийн сургалт зохион байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлыг санхүүжүүлж, төсвийн хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

7. ХХҮЕГ-ын Хяналт, шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад хийх хяналт, шалгалтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн халамжийн төв сан													
1	Нийгмийн халамжийн төв сан	1	19,327.0			1	19,327.0	1	19,327.0				
	Дүн	1	19,327.0			1	19,327.0	1	19,327.0				
Нийгмийн халамжийн дэд сан													
1	Дорноговь аймгийн Нийгмийн халамжийн сан	3	293,472.0			3	293,472.0	3	293,472.0				
	Дүн	3	293,472.0			3	293,472.0	3	293,472.0				
	Нийт дүн	4	312,799.0			4	312,799.0	4	312,799.0				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн халамжийн төв сан													
1	Нийгмийн халамжийн төв сан	8	9,365,327.2			6	1,842,468.0	-	-	1	7,165,185.6	1	365,276.8
	Дүн	8	9,365,327.2			6	1,842,468.0	-	-	1	7,165,185.6	1	365,276.8
Нийгмийн халамжийн дэд сан													
1	Говь-Алтай аймгийн Нийгмийн халамжийн сан	1	44,000.0					1	44,000.0				
2	Ховд аймгийн Нийгмийн халамжийн сан	2	7,255.0					2	7,255.0				
	Дүн	3	51,255.0	-	-	-	-	3	51,255.0	-	-	-	-
	Нийт дүн	11	9,416,582.2	-	-	6	1,842,468.0	3	51,255.0	1	7,165,185.6	1	365,276.8

Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>									
1	Нийгмийн халамжийн төв сан	1	14,978,170.1			1	14,978,170.1		
2	Дорноговь аймгийн Нийгмийн халамжийн сан	1	82,500.0					1	82,500.0
3	Хөвсгөл аймгийн Нийгмийн халамжийн сан	1	-					1	-
	Дүн	3	15,060,670.1			1	14,978,170.1	2	82,500.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 746/А0171139

Улаанбаатар хот

СНДТ-2024/01/АД-СМД-ЗТТЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэмжийг 2017-2023 оны хооронд нийт 35 хүүхдийн 365,276,767.00 /гурван зуун жаран таван сая хоёр зуун далан зургаан мянга долоон зуун жаран долоон/ төгрөгийг 9 асрамжийн төвийн 3 захирал, 2 багш, 4 нийгмийн ажилтны дансаар дамжуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийгмийн халамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.4 -т "16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.", Гэр бүлийн тухай хуулийн 25.3-т "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгож буй тэтгэмжийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, зорилтод бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0325 SNAG-27.Docx

0001089995



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 744/А0171139

Улаанбаатар хот

СХАТ-2024/0118А-СТ/А-35711С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2019-2023 оны хооронд 1000 гаруй хүүхдэд 2,655,220,000.00 /хоёр тэрбум зургаан зуун тавин таван сая хоёр зуун хорин мянган/ төгрөг, тайлант онд 800 гаруй хүүхдэд 943,500,000.00 /есөн зуун дөчин гурван сая таван зуун мянган/ төгрөг олгосон боловч халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, хүүхдийн мөнгөн тэтгэмж зорилтод бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй, мөнгөн хадгаламжид эрсдэл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Асрамжийн төвд байрлах тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд олгож буй тэтгэмжийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй, хүүхдийн мөнгөн тэтгэмж зорилтот бүлэгтээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

0001080997

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/, мэргэжилтэн /Д.Зоригтболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 748/А0171139

Улаанбаатар хот

СНДТ-2024/01/Нд-СТИА-ЗТТЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн халамж хариуцсан мэргэжилтнүүд 11 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн 876,500,000.00 /найман зуун далан зургаан сая таван зуун мянган/ төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг бүртгэх явцад тэтгэмжийн дуусах хугацааг алдаатай оруулсан, үйлчилгээний шифр андуурсан, мөнгөн дүнг буруу бүртгэсэн зэрэг алдаатай бүртгэлийн үйл ажиллагааны улмаас тэтгэмжийг давхардуулан олгож, иргэдээс буцааж суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийгмийн халамжийн сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д "Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг алдаатай, давхардуулан олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/, мэргэжилтэн /Д.Зоригтболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264 30

АТАС-995 9863199
9821020906

Z:\Alban Shaardlagi\2024\0325 SNAG-27.Docx

0001089999



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 949/А0141139

Улаанбаатар хот

СНАГ-2024/01/ӨА-СТНА-ЗТТС

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/105 дугаар тушаалаар ахмад настанд амралтын үйлчилгээ үзүүлэх 29, сувиллын үйлчилгээ үзүүлэх 42 газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, 7,157,582,400.00 /долоон тэрбум нэг зуун тавин долоон сая таван зуун наян хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн санхүүжилт олгосон гэрээний гүйцэтгэлийг дүгнэж акт үйлдээгүй зөрчлийг давтан гаргасан, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Дэлгэрдалайд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 7501/АД171139

Улаанбаатар хот

СХАТ-2024/01/АД - СТИА-3ТЖС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/305 дугаар тушаалаар нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөс 14,809,300.00 /арван дөрвөн сая найман зуун есөн мянга гурван зуун/ төгрөгийн сургалт зохион байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тэвчиж болох зардлыг санхүүжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 951/А0191139

Улаанбаатар хот

СХАТ-2024/01/ХА-СМд-ЗТТГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт, шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад хийх хяналт, шалгалтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /В.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/, Хяналт шалгалт, дотоод аудит мониторингийн газрын дарга /М.Мянганбуу/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ

ATA5663 9686199
05.10.2023

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264210

Z:\Alban.Shaardlaga\2024\0325 SNAG-27.Docx

0001081021



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 752/АО171139

Улаанбаатар хот

СНДТ-2024/01/ХА-СПИД-ЗТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй хувь хүмүүсээс авах 7,603,200.00 /долоон сая зургаан зуун гурван мянга хоёр зуун/ төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зөрчлийг давтан гаргасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0325 SNAG-27.Docx

0001081025



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын

№ 753/᠒᠐᠒4᠒᠑3

Улаанбаатар хот

СНАТ-2024/᠐1/АА-СНА-ИТНЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн халамжийн төв сан шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 14,978,170,091.00 /арван дөрвөн тэрбум есөн зуун далан найман сая нэг зуун далан мянга ерэн нэгэн/ төгрөгийн зарлагын 10 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам -ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Б.АРИУНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

Z:\Alban.Shaardlaga\2024\0325.SNAG-27.Docx

0001781023